| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 54,670,307.00 | 12,590,968.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 16,500,930.00 | 18,630,870.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 80,371,437.00 | 41,837,624.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 41,837,624.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 2,474,900.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 71,171,237.00 | 35,796,985.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,725,300.00 | 6,040,639.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Доржханд гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цэеням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулахдаа нэгдүгээр гарын үсгийг Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Саранцэцэг, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Өлзийбуян нар зурж байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хуулийн дагуу нийгмийн үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2020-2021 оны хичээлийн жилд 61 орон тоотой, нийт 507 сурагч суралцсанаас боловсрол нөхөн олгох хөтөлбөр буюу насан туршийн боловсролоор 37,

бага, дунд, ахлах бүлэгт 470 суралцагчтайгаар үйл ажиллагаагаа явуулсан байна. Тайлант онд нийт 1,062.1 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын даргын 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 131 дугаартай тушаалаар "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг шинэчлэн баталсан нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь аймгийн ТЕЗ-ийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,212,973.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 12,129.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,490.8 мянган төгрөгөөр тогтоосон. 11,087.8

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 7,851.7 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,087.8 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* */мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 137,552.9 | 140,931.9 | 3,379.0 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 16,105.3 | 439.5 | (15,665.7) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 121,447.7 | 140,492.4 | 19,044.7 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,245,999.6 | 1,253,708.4 | 7,708.8 |
| Үндсэн хөрөнгө | 1,753,380.4 | 1,790,957.0 | 37,576.7 |
| Хуримтлагдсан элэгдэл | (507,380.7) | (537,248.6) | (29,867.9) |
| **Нийт хөрөнгө** | 1,383,552.6 | 1,394,640.3 | 11,087.8 |
| Өр төлбөр | 30.8 | 330.7 | 299.9 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,383,521.7 | 1,394,309.6 | 10,787.8 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,383,552.6 | 1,394,640.3 | 11,087.8 |

*Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан*

Авлагын дансны үлдэгдэл 439.5 мянган төгрөг болж 15,665.7 мянган төгрөгөөр буурсан нь авлагыг бууруулж тавилга эд хогшил дансанд 1,025.0 мянга, тоног төхөөрөмж дансанд 14,214.8 мянга, номын дансанд 384.0 мянган төгрөгийн хөрөнгө орлого авсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 140,492.4 мянган төгрөг болж 19,044.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 77,100.4 мянган төгрөгийн хөрөнгө, зардлын тооцооны 3,159.2 мянган төгрөгийн авлагыг бууруулж хөрөнгө орлого авсан, малыг нас дэвшүүлж авсны зөрүү 14,735.0 мянга, аймгийн Засаг даргын Тамгын газар, НҮБ болон БСУГ-аас үнэ төлбөргүй олгосон 5,306.0 мянга, нийт 100,300.6 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэж, байгууллагын даргын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 137 дугаартай тушаалаар акталсан 9,780.1 мянга, зарцуулсан 71,475.7 мянга нийт 81,255,9 мянган төгрөгийн зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,512,609.3 мянган төгрөг болж 52,912.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 33,151.4 мянга, зардлын тооцооны 9,885.0 мянган төгрөгийн авлагыг бууруулж хөрөнгө орлого авсан, аймгийн Засаг даргын Тамгын газраас үнэ төлбөргүй олгосон 3,555.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Аз хур ХХК-наас олгосон 384.0 мянган төгрөгийн ном, төгсөлтийн хамт олноос олгосон 1,799.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 48,775.2 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 137 дугаар тогтоолоор 11,198.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталсантай холбоотой байна.

Байгууллагын санхүүгийн тайланд өглөгийн үлдэгдэл 330.7 мянган төгрөг болж 299.9 мянган төгрөгөөр өссөн нь Нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу шилжүүлсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,394,309.6 мянган төгрөг болж 10,787.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 10,787.8 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,256,828.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 316,784.6 мянган төгрөгөөр бууруулж 940,043.4 мянган төгрөгөөр анх батлагдсан бөгөөд тайлант онд төсөвт 3 удаа өөрчлөлт хийж 2021 оны 12 дугаар сард 1,062,955.0 мянган төгрөгөөр тодотгосон байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,062,955.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 958,832.0 мянга, орон нутгийн төсвөөс 104,123.0 мянга нийт 1,062,955.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,042,290.6 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 887.0 мянга, улсын төсөвт 19,777.3 мянга, нийт 20,664.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,042,290.6 мянган төгрөг буюу 98,06 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлаас 5,323.7 мянга, олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 477.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 886.9 мянга, хангамж бараа материалын зардал 12.5 мянга, нормативд зардлаас 10,317.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 237.2 мянга, бусад урсгал шилжүүлэг 3,873.1 мянган төгрөг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 6,040.6 мянга, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан санхүүжилт 35,797.0 мянга, нийт 41,837.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 12,591.0 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 18,630.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжинд 10,615.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилт 27 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 91.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 1,121,673. мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 91,299.7 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, бусад урсгал шилжүүлэг, бараа үйлчилгээний бусад зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 1,103,906.6 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,090,733.6 мянган төгрөгийн 116 мэдээллийг хугацаанд нь, 52,071.9 мянган төгрөгийн 33 мэдээлэл хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна.

*Хүснэгт 2. Шилэн дансны мэдээлэл*

| д/д | Хугацаа | Төрөл | Мэдээлвэл зохих/удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | 0 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 3 | 1 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 22 | 14 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 78 | 18 | |
| | Нийт | 27 | 151 | 116 | 33 | 2 |

*Эх сурвалж:Шилэн дансны нэгдсэн системээс*

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тайлант онд 1,062,955.0 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 1,042,290.6 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардал болох 79,890.1 мянган төгрөгөөс 19,777.3 мянган төгрөгийн хэмнэлт гаргасан нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Мөн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 103,123.0 мянган төгрөгөөр баталж 102,236.0 мянган төгрөгийг зарцуулж нийт 20,624.6 мянган төгрөг хэмнэхээс 19,737.6 мянган төгрөгийг хэмнээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалттай нийцэхгүй байна.

### 3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 34,743.5 мянган төгрөгийн 5 алдаа зөрчилд 2 зөвлөмж, 2 албан шаардлага, 1 санхүүгийн тайлангийн залруулга, 2,430 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосон бөгөөд хэрэгжилтийг Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021.06.11-ны өдрийн 53 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12,711.2 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 12,632.0 мянган төгрөгийн 1 алдааг Сангийн яамны Э-тайланд залруулж, 79,2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчил давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүллээ.

### 4.1 Залруулсан алдаа

Тайлант оны санхүүгийн тайлангаар бараа материалын 35110 данс буюу тусгай зориулалтын дансны үлдэгдэл 7,826.9 мянга, 35470 данс буюу түрээсийн сурах бичгийн дансны үлдэгдэл 4,805.1 мянган төгрөг байхад Э-тайланд 2 дансны үлдэгдлийг зөрүүлж шивсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", санхүүгийн тайлангийн "Ангилал", "Оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Сангийн яамны Э-тайланд 2 дансны үлдэгдэл 12,632.0 мянган төгрөгийг залруулав.

### 4.2 Төлбөрийн акт

1 Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн Дугаар 131/ШШ2021/00277 дугаар бүхий захирамжийн дагуу тус сургуулийн технологийн багш ажилтай Б.Санжсүрэн, сургуулийн захирал Б.Саранцэцэг нартай холбоотой тэмдэгтийн хураамж 35.1 мянга, ажилгүй байсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэл 44.1 мянган төгрөг нийт 79.2 мянган төгрөгийг байгууллагын төсвөөс гаргасан байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1. “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.”, Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5. “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын төсвөөс төлсөн тэмдэгтийн хураамж 35.1 мянга, ажилгүй байсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэл 44.1 мянга нийт 79.2 мянган төгрөгийг сургуулийн захирал Б.Саранцэцэгээр төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

### 4.3 Аудитын зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал***

1. Шилэн дансны цахим сайтад нийт 1,103,906.6 мянган төгрөгийн 151 мэдээлэл оруулахаас 1,090,733.6 мянган төгрөгийн 116 мэдээлэл оруулсан бөгөөд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 52,071.9 мянган төгрөгийн орлого, зарлагын мөнгөн гүйлгээ болон нийт 33 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>* Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх.

2. Тайлант онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 103,123.0 мянган төгрөгөөр баталж 102,236.0 мянган төгрөгийг зарцуулж, нийт 20,624.6 мянган төгрөг хэмнэхээс 19,737.6 мянган төгрөгийг хэмнээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалттыг зөрчсөн байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*

Цаашид байгууллагын удирдлага төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

**Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мян. төгрөгөөр/

| № | Төсвийн захирагчийн ангилал | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | ТШЗ | 2 | 12,711.2 | 1 | 12,632.0 | 1 | 79,2 | | | | |
| | **Дүн** | **2** | 12,711.2 | 1 | 12,632.0 | 1 | 79,2 | | | | |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Шилэн данс | 1 | 52,071.9 | | | | | | | 1 | 52,071.9 |
| 2 | ЗГ-ын 43 дугаар тогтоол | 1 | 19,737.6 | | | | | | | 1 | 19,737.6 |
| | **Дүн** | **2** | **71,809.6** | | | | | | | **2** | **71,809.6** |
| | **НИЙТ ДҮН** | **4** | **84,520.8** | 1 | 12,632.0 | 1 | 79,2 | | | **2** | **71,809.6** |

oOo



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 12 сарын 20 өдөр Дугаар 07/А0570643 Номгон
БНА-2022/57/НА-СТА-ТШ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн завсрын аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн Дугаар 131/ШШ2021/00277 дугаар бүхий захирамжийн дагуу тус сургуулийн технологийн багш ажилтай Б.Санжсүрэн, сургуулийн захирал Б.Саранцэцэг нартай холбоотой тэмдэгтийн хураамж 35100, ажилгүй байсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэл 44100 төгрөг нийт 79200 төгрөгийг байгууллагын төсвөөс гаргасан байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1. “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.”, Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5. “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь

“Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

Байгууллагын төсвөөс төлсөн тэмдэгтийн хураамж 35100, ажилгүй байсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэл 44100 төгрөг нийт 79200 төгрөгийг сургуулийн захирал Б.Саранцэцэгээр төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

1. Актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2021 оны 12 дугаар сарын 25-ны дотор багтаан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг[1], Жаргалант сумын сургуулийн нягтлан бодогч Б.Өлзийбуянд хариуцуулав[2].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ

АУДИТОР Л.ДОРЖХАНД

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

[3] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно